

Г Хот байгуулалт, төлөвлөлтийг боловсронгуй болгох тухай Г

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хот байгуулалт, төлөвлөлтийг боловсронгуй болгох асуудал” сэдэвт хэлэлцүүлгээс гаргасан санал, дүгнэлттэй ажлын журмаар танилцаад ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон хуучин барилга байшинг буулгах, шинээр төлөвлөж барих, нийтийн эзэмшлийн зориулалтын дэд бүтэц, барилга байгууламж барих зорилгоор газрыг улсын мэдэлд эргүүлэн авах харилцааг зохицуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх;
2. Барилгын чанарын хяналтыг олон улсын жишгийн дагуу хувийн хэвшлийн нэр хүнд бүхий байгууллагуудад хариуцуулан гүйцэтгүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;
3. Нийслэл хотын хүн амын даацыг харгалзан үзэж, нийслэл хотод хуваарилах улсын төсвийн хөрөнгө оруулалтыг шат дараатайгаар нэмэгдүүлэх бодлого баримтлах.

Хоёр. Монгол Улсын Засгийн газарт:

1. Орон сууц, дэд бүтцийн барилга байгууламжуудыг барих зураг төслийн ажлыг шаардлагын түвшинд өндөр чанартай боловсруулах эрх зүй, зохион байгуулалтын нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай бол хөрөнгийн тусгай сан байгуулах;

2. Газар хөдлөлт, гамшгийн нөхцөлд нийслэл хотын эрчим хүч, дулааны хангамжийн аюулгүй нөхцөлийг хангах, хот байгуулалт, дагуул хотуудыг хөгжүүлэх шаардлагыг харгалзан эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох асуудлыг 2011 оны эхний хагас жилд багтаан судалж, холбогдох шийдвэрийг гаргах.